



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2023 оны 05 сарын 02 өдөр

Дугаар 165

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас
балансад шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны “Зөвшөөрөл олгох тухай” 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу татан төвлөрүүлсэн 3 нэрийн нийт 68,732,553.00 (жаран найман сая долоон зуун гучин хоёр мянга таван зуун тавин гурван) төгрөгийн балансын үнэ, 60,770,054.30 (жаран сая долоон зуун далан долоон мянга тавин дөрвөн төгрөг гучин мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийг хавсралтад заасны дагуу Говь-Алтай аймаг дахь Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв, Боомтын сэргэлтийн үндэсний хороонд тус тус балансаас балансад шилжүүлсүгэй.

2.Говь-Алтай аймаг дахь Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Батсанчир, Боомтын сэргэлтийн үндэсний хорооны ажлын албаны дарга Т.Төрболд нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Автомашиныг улсын бүртгэлээс шилжүүлж, арга хэмжээний биелэлтийг 2023 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132005007
11-r_huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2023 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн
165 дугаар тогтоолын хавсралт

ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ДАГУУ ТАТСАН,
БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Шилжүүлэн өгөх хуулийн этгээдийн нэр	Автомашинны нэр, улсын дугаар	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)		Үлдэх өртөг	Шинэчлэн тогтоосон үнэ	Цаашид ашиглах хугацаа (жил)		Шилжүүлэн авах хуулийн этгээдийн нэр
				Хуримтлагдсан элэгдэл	Хуримтлагдсан элэгдэл			Цаашид ашиглах хугацаа	Цаашид ашиглах хугацаа	
1	"Төрийн орон сууцны корпораци" ТӨХХК	Хьюндай Соната-6, 10-11 УБЗ	38,850,300.00	33,250,301.30	5,599,998.70					Говь-Алтай аймаг дахь МСҮТ
2	Үндэсний урлагийн их театр	Тоёота Альфард, 09-60 УНГ	2,700,000.00	337,500.00	2,362,500.00					Боомтын сэргэлтийн үндэсний хороо (Боршоо хилийн боомт)
3	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар	Соната-6, 01-40 УБЗ	27,182,253.00	27,182,253.00	-	4,000,000.00		4.00		
	Нийт дүн	-	68,732,553.00 (жаран найман сая долоон зуун гучин хоёр мянга таван зуун тавин гурван)	60,770,054.30 (жаран сая долоон зуун далан мянга тавин дөрвөн төгрөг гучин мөнгө)	7,962,498.70 (долоон сая есөн зуун жаран хоёр мянга дөрвөн зуун ерэн найман төгрөг далан мөнгө)		4,000,000.00 (дөрвөн сая)	-		-